

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2026/054/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Алтай хот
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа
Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг
Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Цэрэнханд
Утас: 99086371 Цахим хаяг: Tserenkhand@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2026.02.24 № 95

танай _____ -ны № _____ -т

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Д.ЭРДЭНЭЖАРГАЛ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доор зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- Тус байгууллагын дансанд бүртгэлтэй олон жилийн насжилттай 264,522.8 мянган төгрөгийн өвс, тэжээлийн авлагын эзэн холбогдогч тодорхой бус, тооцоо нийлж баталгаажуулаагүй,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль болон баталсан бүтэц орон тооны хязгаарыг зөрчин аймгийн Засаг даргын орлогч 1-ээр илүү ажиллуулан 61,106.2 мянган төгрөгийн, 1-8 дугаар сард зөвлөх ажиллуулан 37,741.4 мянган төгрөгийн, 9-12 дугаар сард төслийн зохицуулагч орон тоог бий болгон 16,404.0 мянган төгрөгийн, нийт 115,251.6 мянган төгрөгийн цалин олгож, төсвийг үрэлгэн зарцуулсан,

822505000264

- Байгууллагын нэр дээрх 5315620466 тоот картын дансаар дамжуулан, ангилагдаагүй бусад арга хэмжээний зардлаас 131,132.7 мянган төгрөгийг бэлнээр касст гарган авч зарцуулсан ба бэлэн мөнгөний орлого, зарлагын гүйлгээний анхан шатны баримтгүй,
- Шатахууны зардлаас 127,894.9 мянган төгрөг буюу 58.0 хувийг гаднын автомашинд хийж зарцуулсан боловч жолоочийн тооцооны хуудас хөтлөөгүй, тооцоо бодоогүй, зарцуулалт тодорхой бус, шатахууны 89,268.1 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэж, төсвийг зохистой удирдаагүй,
- Төсвийн бусад хөрөнгө буюу хөрөнгө оруулалтын зардлаас 246,500.0 мянган төгрөгийн, шатахууны зардлаас 65,492.4 мянган төгрөгийн, урсгал засвараас 65,129.0 мянган төгрөгийн, багаж техник хэрэгсэл худалдан авах зардлаас 61,026.0 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, өмнөх зөрчлийг давтан гаргасан,
- Албан хаагчдад 12 дугаар сард нэг өдөрт 45.0 мянган төгрөгөөр тооцож, нийт 40,315.0 мянган төгрөгийн хоолны мөнгийг нэмж олгон, төсөвт тусгаагүй зардал гаргасан,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчин урсгал төсвөөс 299,252.1 мянган төгрөгийг дараах арга хэмжээнүүдэд зарцуулсан байна. Үүнд:
- Аймгийн Засаг даргаас бусад алба нэгжийн хэлтсийн дарга нар суудлын автомашин ашиглаж, 33,977.0 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан,
- Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар бараа үйлчилгээний бусад зардлын төсвөөс 33,010.3 мянган төгрөгийн хоол, хүнс, буудлын төлбөрт 27,363.3 мянган төгрөгийг зарцуулсан,
- Аймгийн баяр наадмын зардалд 191,832.0 мянган төгрөгийг анхан шатны баримтгүй, үр ашиггүй, арвилан хэмнэлтгүй зарцуулж, 8,000.0 мянган төгрөгөөр айраг ундаа авсан,
- Нэгдсэн үндэсний байгууллагын санхүүжилтээс өмнөх оны дотоод албан томилолтын зардал 7,070.0 мянган төгрөгийг олгосон боловч өр төлбөрийг дансанд бүртгээгүй, ажлын тайлан, илтгэх хуудасгүй, 3,500.0 мянган төгрөгийг шатахууны зарцуулалтын баримтын бүрдэл хангалтгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5, 22 дугаар зүйлийн 22.1, 24 дүгээр зүйлийн 24.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 5.3, 11 дүгээр зүйлийн 11.1, 12 дугаар зүйлийн 12.1, 15 дугаар зүйлийн 15.1.3, 15.2.5 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 377 дугаар тогтоолтой нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын үнэлгээ хуваарилалт, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд орон нутгийн төсвөөс 6,337,491.3 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан нь өмнөх оноос 557,586.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд өвс, тэжээлийн орлого 55,979.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна

Засгийн газрын 2021 оны 377 дугаар тушаалаар 55 орон тоотой байхаар баталсан ба гүйцэтгэлээр 58 орон тоотой ажиллаж байна. Засгийн газрын тогтоолоор шинээр байгуулсан Архивын тасгийн ашиглаж байгаа барилга, байгууламж, хөрөнгийг шилжүүлээгүй байна.

Аудитын гол асуудал

Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журмын дагуу шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг олгох бүрэн эрхийг Засаг даргад олгохоор байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуультай нийцэхгүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчин Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 27,363.6 мянган төгрөгийн гарын бэлэг өгч, 107,308.7 мянган төгрөгийн хоол хүнс, буудлын төлбөр төлж, 95,736.0 мянган төгрөгийг иргэн, хуулийн этгээдэд буцалтгүй тусламж, дэмжлэг олгон, 102,768.1 мянган төгрөгийг жуух бичгийн шагналд, хэвлэл контентын үйлчилгээнд 39,838.3 мянган төгрөг, нийт 373,014.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Тайлант онд 345,672.8 мянган төгрөгийн өвс тэжээл, татаас санхүүжилтийн авлага, 112,295.9 мянган төгрөгийн ХХОАТ, тээвэр шатахуун, бичиг хэрэг, шуудан холбоо, дотоод албан томилолтын өглөг үүсгэсэн байна.

Бусад асуудал

Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, журамд заасан хугацаанд батлуулсан бөгөөд нийт 4 зорилгын 27 зорилтын хүрээнд 192 арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Нийт 192 арга хэмжээнээс 175 нь бүрэн хангалттай, 6 нь хангалттай, 9 нь хангалтгүй, 2 нь үнэлэх боломжгүй, хэрэгжилт 96.2 хувьтай байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Б. ГҮНЖИДМАА

Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,191,659,465.31</u>	<u>1,409,637,579.30</u>
33	АВЛАГА	373,051,896.82	345,672,896.29
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,469,768.20	1,779,815.93
335	Бусад авлага	371,582,128.62	343,893,080.36
3351	Байгууллагаас авах авлага	313,555,859.85	285,866,811.59
3352	Хувь хүмүүсээс авах авлага	58,026,268.77	58,026,268.77
35	БАРАА МАТЕРИАЛ	818,607,468.00	1,063,964,683.01
354	Хангамжийн материал	818,607,468.00	1,063,964,683.01
35410	Бичиг хэргийн материал	2,503,000.00	2,280,400.00
35420	Аж ахуйн материал	816,104,468.00	1,061,684,283.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>9,436,997,688.28</u>	<u>9,450,378,658.61</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	9,436,997,688.28	9,450,378,658.61
392	Биет хөрөнгө	5,447,247,116.61	5,472,004,869.10
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,911,795,050.05	4,911,795,050.05
39202	Хуримтлагдсан элэгдэл	(278,406,298.45)	(360,269,549.17)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	595,384,000.00	897,884,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(268,720,203.31)	(452,495,998.53)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	696,949,576.65	806,545,143.65
39206	Хуримтлагдсан элэгдэл	(415,837,708.22)	(523,195,025.17)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	391,916,821.56	400,694,110.56
39208	Хуримтлагдсан элэгдэл	(218,216,343.79)	(237,024,251.09)
39214	Бусад үндсэн хөрөнгө	58,111,073.00	58,111,073.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(25,728,850.88)	(30,039,684.20)
393	Биет бус хөрөнгө	3,989,750,571.67	3,978,373,789.51
39301	Програм хангамж	153,548,755.00	153,548,755.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(103,302,183.33)	(114,678,965.49)
39303	Бусад биет бус хөрөнгө	3,939,504,000.00	3,939,504,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>10,628,657,153.59</u>	<u>10,860,016,237.91</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>185,230,027.95</u>	<u>112,295,953.58</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	185,230,027.95	112,295,953.58
413	Өглөг	185,230,027.95	112,295,953.58
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	134,347,240.01	4,572,013.89
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	50,342,687.45	107,723,939.69
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>10,443,427,125.64</u>	<u>10,747,720,284.33</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	10,443,427,125.64	10,747,720,284.33
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,462,089,412.49	1,462,089,412.49
51101	Өмч: - төрийн	1,462,089,412.49	1,462,089,412.49
512	Хуримтлагдсан үр дүн	8,491,065,284.67	8,795,358,443.36
51210	Өмнөх үеийн үр дүн	7,865,317,165.33	8,491,065,284.67
51220	Тайлант үеийн үр дүн	625,748,119.34	304,293,158.68
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	490,272,428.48	490,272,428.48
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>10,628,657,153.59</u>	<u>10,860,016,237.91</u>

Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	7,034,434,688.98	7,027,380,550.77
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	661,628,309.98	353,929,015.27
120	Нийтлэг татварын бус орлого	661,628,309.98	353,929,015.27
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	661,628,309.98	353,929,015.27
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,265,300.00	7,808,629.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	646,363,009.98	346,120,386.27
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,372,806,379.00	6,673,451,535.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	592,901,096.00	335,960,235.50
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	176,103,035.00	30,210,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	101,964,400.00	200,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	314,471,061.00	105,750,235.50
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	5,779,905,283.00	6,337,491,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	5,779,905,283.00	6,337,491,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	6,408,686,569.64	6,723,087,392.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,408,686,569.64	6,636,587,392.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,080,818,733.38	6,122,253,492.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,373,790,523.44	2,483,390,834.55
210101	Үндсэн цалин	2,373,790,523.44	2,438,739,294.55
210105	Гэрээт ажлын хөлс	-	44,651,540.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	270,168,155.03	288,194,438.80
210201	Тэтгэврийн даатгал	270,168,155.03	288,194,438.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	360,027,436.23	408,225,055.80
210301	Гэрэл, цахилгаан	24,306,646.12	34,108,277.52
210302	Түлш, халаалт	298,971,594.11	334,073,566.28
210303	Цэвэр, бохир ус	36,749,196.00	40,043,212.00
2104	Хангамж, бараа материалын зардал	344,785,359.76	213,673,203.12
210401	Бичиг хэрэг	26,854,550.00	18,063,650.00
210402	Тээвэр, шатахуун	284,550,772.89	171,868,519.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	22,314,036.87	23,741,034.12
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	78,207,285.00	42,419,250.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,300,000.00	4,664,800.00
210604	Урсгал засвар	73,907,285.00	37,754,450.00
2107	Томилолт, зочны зардал	92,555,700.00	83,708,226.00
210701	Гадаад албан томилолт	-	21,648,606.00
210702	Дотоод албан томилолт	92,555,700.00	62,059,620.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,059,473,842.80	1,834,649,279.59
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,059,473,842.80	1,801,975,414.57
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	2,682,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	4,400,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	949,001.02
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	121,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	4,623,500.00
210807	Газрын төлбөр	-	19,897,864.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	501,810,431.12	767,993,204.23
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	201,322,188.00	437,417,970.85
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	256,231,583.12	330,575,233.38
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	327,867,836.26	514,333,900.00

Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2132	Бусад урсгал шилжүүлэг	238,328,121.00	92,944,458.70
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	108,199,071.00	86,602,458.70
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	25,083,450.00	6,342,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	421,389,441.30
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	421,389,441.30
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	86,500,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	86,500,000.00
223001	Бусад хөрөнгө	-	86,500,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	625,748,119.34	304,293,158.68

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1.00	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	6,384,809,744.00	6,730,293,164.50
12.00	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	23,865,300.00	56,841,629.00
120.00	Нийтлэг татварын бус орлого	23,865,300.00	56,841,629.00
120,004.00	Төсөв байгууллагын өөрийн орлого	23,865,300.00	56,841,629.00
1,200,042.00	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	23,865,300.00	56,841,629.00
13.00	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,360,944,444.00	6,673,451,535.50
1,311.00	Нэмэлт санхүүжилтийн орлого	581,039,161.00	335,960,235.50
131,101.00	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	164,241,100.00	30,210,000.00
131,103.00	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	101,964,400.00	200,000,000.00
131,104.00	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	314,471,061.00	105,750,235.50
1,320.00	Орон нутгийн төсвөөс санхүүжих	5,779,905,283.00	6,337,491,300.00
132,001.00	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	5,779,905,283.00	6,337,491,300.00
2.00	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	6,194,868,144.00	6,437,488,264.99
21.00	УРСГАЛ ЗАРДАЛ	6,194,868,144.00	6,437,488,264.99
210.00	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,865,000,307.74	5,902,186,197.99
2,101.00	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,292,743,180.42	2,581,932,665.03
210,101.00	Үндсэн цалин	1,313,721,876.91	1,485,430,712.91
210,102.00	Нэмэгдэл	718,063,673.70	775,895,041.40
210,103.00	Унаа хоолны хөнгөлөлт	185,306,133.26	222,147,823.76
210,104.00	Урамшуулал	75,651,496.55	98,459,086.96
2,102.00	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	215,712,920.00	290,024,508.40
210,201.00	Тэтгэврийн даатгал	170,617,614.00	217,015,250.00
210,202.00	Тэтгэмжийн даатгал	6,051,665.00	24,504,609.40
210,203.00	ҮОМШӨ-ний даатгал	2,800,000.00	4,745,296.00
210,205.00	Эрүүл мэндийн даатгал	33,443,641.00	43,759,353.00
2,103.00	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	395,483,236.33	423,087,609.68
210,301.00	Гэрэл, цахилгаан	24,306,646.12	34,108,277.52
210,302.00	Түлш, халаалт	339,098,874.21	344,264,640.16
210,303.00	Цэвэр, бохир ус	32,077,716.00	44,714,692.00
2,104.00	Хангамж, бараа материалын зардал	157,063,391.99	98,018,597.00
210,401.00	Бичиг хэрэг	24,243,400.00	10,061,950.00
210,402.00	Тээвэр, шатахуун	97,790,820.00	65,492,400.00
210,403.00	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	21,213,171.99	22,464,247.00
2,106.00	Эд хогшил, урсгал засварын зардал	83,978,490.00	76,668,910.00
210,601.00	Багаж, техник, хэрэгсэл	5,172,000.00	30,629,800.00
210,602.00	Тавилга	5,179,800.00	3,860,000.00

Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210,604.00	Урсгал засвар	73,626,690.00	42,179,110.00
2,107.00	Томилолт, зочны зардал	84,999,700.00	87,262,226.00
210,701.00	Гадаад албан томилолт	-	21,648,606.00
210,702.00	Дотоод албан томилолт	84,999,700.00	65,613,620.00
2,108.00	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,347,101,201.00	1,799,688,800.08
210,801.00	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,347,101,201.00	1,769,696,935.06
210,803.00	Даатгалын үйлчилгээ	-	4,400,000.00
210,804.00	Тээврийн хэрэгслийн татвар	-	949,001.02
210,805.00	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	121,500.00
210,806.00	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	4,623,500.00
210,807.00	Газрын төлбөр	-	19,897,864.00
2,109.00	Бараа үйлчилгээний бусад зардал	287,918,188.00	545,502,881.80
210,901.00	Бараа үйлчилгээний бусад зардал	240,634,728.00	545,502,881.80
213.00	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	329,867,836.26	535,302,067.00
2,132.00	Бусад урсгал шилжүүлэг	240,328,121.00	92,944,458.70
213,207.00	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	108,199,071.00	86,602,458.70
213,209.00	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	27,083,450.00	6,342,000.00
2,133.00	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	442,357,608.30
213,303.00	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	442,357,608.30
3.00	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	189,941,600.00	292,804,899.51
5.00	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	189,941,600.00	292,805,000.00
22.00	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	189,941,600.00	292,805,000.00
2,200.00	Дотоод эх үүсвэрээр	189,941,600.00	292,805,000.00
223,001.00	Бусад хөрөнгө	-	33,500,000.00
225,106.00	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	189,941,600.00	259,305,000.00
6.00	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(189,941,600.00)	(292,805,000.00)
8.00	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	(100.49)
9.00	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	100.49

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 1-р сарын 1-нэрэх үлдэгдэл	1,462,089,412.49	490,272,428.48	8,491,065,284.67	10,443,427,125.64
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,462,089,412.49	490,272,428.48	8,491,065,284.67	10,443,427,125.64
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
C07	Тайлант үеийн үр дүн				0.00
C08	2024 оны 12-р сарын 31-нэрэх үлдэгдэл	1,462,089,412.49	490,272,428.48	8,491,065,284.67	10,443,427,125.64
D01	2025 оны 1-р сарын 1-нэрэх үлдэгдэл	1,462,089,412.49	490,272,428.48	8,491,065,284.67	10,443,427,125.64
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,462,089,412.49	490,272,428.48	8,491,065,284.67	10,443,427,125.64



Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	304,293,158.68	304,293,158.68
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,462,089,412.49	490,272,428.48	8,795,358,443.36	10,747,720,284.33

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

	ҮЗҮҮЛЭЛТ	БАТАЛСАН ТӨСӨВ	ГҮЙЦЭТГЭЛ	ХЭТРЭЛТ, ХЭМНЭЛТ	ХУВЬ
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,337,494,300.0	5,973,246,769.19	364,247,530.81	94.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,017,494,300.0	5,779,746,769.2	237,747,530.8	96.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,862,901,200.0	5,686,802,310.49	176,098,889.5	97.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,453,302,900.0	2,581,932,665.03	(128,629,765.0)	105.2
210101	Үндсэн цалин	2,325,878,100.0	1,485,430,712.91	840,447,387.1	63.9
210102	Нэмэгдэл	127,424,800.0	775,895,041.40	(648,470,241.4)	608.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	222,147,823.76	(222,147,823.8)	#DIV/0!
210104	Урамшуулал	-	98,459,086.96	(98,459,087.0)	#DIV/0!
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	290,734,800.0	290,024,508.40	710,291.6	99.8
210201	Тэтгэврийн даатгал	203,078,800.0	217,015,250.00	(13,936,450.0)	106.9
210202	Тэтгэмжийн даатгал	21,914,000.0	24,504,609.40	(2,590,609.4)	111.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,957,000.0	4,745,296.00	6,211,704.0	43.3
210204	Ажилгүйдлийн даатгал	10,957,000.0	-	10,957,000.0	-
210205	Эрүүл мэндийн даатгал	43,828,000.0	43,759,353.00	68,647.0	99.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	435,618,500.0	423,087,609.68	12,530,890.3	97.1
210301	Гэрэл, цахилгаан	35,000,000.0	34,108,277.52	891,722.5	97.5
210302	Түлш, халаалт	365,618,500.0	344,264,640.16	21,353,859.8	94.2
210303	Цэвэр, бохир ус	35,000,000.0	44,714,692.00	(9,714,692.0)	127.8
2104	Хангамж, бараа материалын зардал	137,000,000.0	98,018,597.00	38,981,403.0	71.5
210401	Бичиг хэрэг	13,000,000.0	10,061,950.00	2,938,050.0	77.4
210402	Тээвэр, шатахуун	100,000,000.0	65,492,400.00	34,507,600.0	65.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	24,000,000.0	22,464,247.00	1,535,753.0	93.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	150,000,000.0	130,025,300.00	19,974,700.0	86.7
210601	Багаж, техник, хэрэгсэл	79,000,000.0	61,026,000.00	17,974,000.0	77.2
210602	Тавилга	20,000,000.0	3,860,000.00	16,140,000.0	19.3
210604	Урсгал засвар	51,000,000.0	65,139,300.00	(14,139,300.0)	127.7
2107	Томилолт, зочны зардал	122,000,000.0	87,262,226.00	34,737,774.0	71.5
210701	Гадаад албан томилолт	22,000,000.0	21,648,606.00	351,394.0	98.4
210702	Дотоод албан томилолт	100,000,000.0	65,613,620.00	34,386,380.0	65.6



Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,715,628,800.0	1,693,831,712.58	21,797,087.4	98.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,681,003,000.0	1,663,839,847.56	17,163,152.4	99.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,000,000.0	949,001.02	1,050,999.0	47.5
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	165,000.0	121,500.00	43,500.0	73.6
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,100,000.0	4,623,500.00	2,476,500.0	65.1
210807	Газрын төлбөр	20,960,800.0	19,897,864.00	1,062,936.0	94.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	558,616,200.0	382,619,691.80	175,996,508.2	68.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	558,616,200.0	382,619,691.80	175,996,508.2	68.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	154,593,100.00	92,944,458.70	61,648,641.30	60.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	154,593,100.0	92,944,458.70	61,648,641.3	60.1
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	144,393,100.0	86,602,458.70	57,790,641.3	60.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,200,000.0	6,342,000.00	3,858,000.0	62.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	320,000,000.0	193,500,000.00	126,500,000.0	60.5
2200	Дотоод эх үүсвэрээр	320,000,000.0	193,500,000.00	126,500,000.0	60.5
223001	Бусад хөрөнгө	320,000,000.0	193,500,000.00	126,500,000.0	60.5
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6,337,494,300.0	5,973,246,668.70	364,247,631.3	94.3
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	6,337,494,300.0	5,973,246,668.70	364,247,631.3	94.3
132001	Орон нутгийн төсвөөс	6,337,494,300.0	5,973,246,668.70	364,247,631.3	94.3

2.6 Нэмэлт санхүүжилтийн тайлан

	ҮЗҮҮЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭЛ
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	336,822,554.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	336,822,554.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	314,688,887.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,599,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,599,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	110,257,087.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	110,257,087.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	199,832,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	199,832,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,133,667.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	22,133,667.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,133,667.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	336,822,554.5
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	336,822,554.50
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	30,210,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	200,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	105,750,235.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	862,319.00

Гурав. Аудитын илрүүлэлт:

3.1 Аудитын залруулга

Залруулсан алдаа

- Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой: Нэмэлт санхүүжилтийн дансаар орж ирсэн 862.3 мянган төгрөгийн орлогыг үндсэн дансны туслах үйл ажиллагааны орлогоор тайлагнасан,
- Нэмэлт санхүүжилтийн данснаас төвлөрүүлсэн 22,133.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт 213303 эдийн засгийн ангиллаар тайлагнасныг тус тус залрууллаа.
- Мэдээллийг орхигдуулсантай холбоотой: Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 14,949,023.1 мянган төгрөгийн 333 мэдээллээс, цалингаас бусад 5 саяаас дээш зарлагын 975,735.6 мянган төгрөгийн 20 гүйлгээг мэдээлээгүйг нөхөн байршуулсан.

Залруулагдаагүй нийт 1,431,154.3 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 1,431,154.3 мянган төгрөгийн 9 зөрчил¹ илэрч 551,222.2 мянган төгрөгийн 4 зөрчил арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага, 879,932.1 мянган төгрөгийн 5 зөвлөмжийг хүргүүллээ.

3.2 Албан шаардлага

1. Төсөвт тусгагдаагүй байхад ажиллагсад 12 дугаар сард 17 өдөр 45.0 мянган төгрөгөөр тооцож, нийт 40,315.0 мянган төгрөгийн хоолны мөнгийг давхардуулан олгож төсвийг үрэлгэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Баталсан төсөвт тусгаагүй хоолны мөнгө давхардуулан олгож байгаа зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн.

2. Төрийн хэмнэлтийн тухай хууль болон баталсан бүтэц орон тооны хязгаарыг зөрчин аймгийн Засаг даргын орлогч 1-ээр илүү ажиллуулан 61,106.2 мянган төгрөгийн, 1-8 сард зөвлөх ажиллуулан 37,741.4 мянган төгрөгийн, 9-12 сард төслийн зохицуулагч орон тоог бий болгон 16,404.0 мянган төгрөгийн, нийт 115,251.6 мянган төгрөгийн цалин олгож, төсвийг хохироосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-т "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т "Нийслэлийн Засаг дарга хоёр, аймаг, дүүрэг, сумын Засаг дарга нэгээс илүү орлогч даргатай байхыг хориглоно", 5.3-т "Засгийн газрын агентлагийн дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд зөвлөх чиг үүрэг бүхий орон тооны этгээд ажиллуулахыг хориглоно", 5.4-т "Энэ асуудлыг зааврыг зөрчиж, дэд тэргүүн, дэд орлогч, орлогч дарга, чиг хандлагын ижил эрх, эрх бүхий өөр нэршилтэй албан тушаалын орон тоо бий болгох, албан тушаалтныг томилох, орон тоог ажиллуулахыг зөвшөөрөхгүй. Нэгэн эрх, хүчээр өөр нэршилтэй албан тушаалын орон тоо бий болгох, дээр нь албан тушаалтныг томилох, орон тоог ажиллуулахыг зөвшөөрнө", Засгийн газрын 2025

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

оны 37 дугаар "Аймгийн засаг даргын Тамгын газрын бүтэц орон тооны хязгаарыг тогтоох тухай" тогтоолтой нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Орон тооноос илүү ажиллаж байгаа Засаг даргын Зөвлөх, Төслийн зохицуулагчийг чөлөөлөх албан шаардлага хүргүүлсэн.

3. Тус байгууллагын дансанд бүртгэлтэй олон жилийн насжилттай 264,522.8 мянган төгрөгийн өвс тэжээлийн авлага үүсгэсэн боловч эзэн холбогдогч тодорхой бус тооцоо нийлж баталгаажуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тооцоо нийлж баталгаажуулаагүй өвс тэжээлийн авлагыг харилцагч тус бүрээр тооцоо нийлж баталгаажуулан зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

4. Байгууллагын нэр дээрх 5315620466 тоот картын дансаар дамжуулан, ангилагдаагүй бусад арга хэмжээний зардлаас 131,132.7 мянган төгрөгийн 39 гүйлгээгээр касст бэлэн мөнгө авч зарцуулсан ба бэлэн мөнгөний орлого, зарлагын гүйлгээний анхан шатны баримтгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", Говь-Алтай аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн багцын төсөвт байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Тавдугаар бүлэг: Нягтлан бодох бүртгэлийн тусгай бодлого, горим, 5.1 Мөнгөн хөрөнгийн бүртгэл төсөвт байгууллага нь бага хэмжээний үнийн дүнтэй бараа, ажил үйлчилгээний болон банкны харилцах дансгүй этгээдийн төлбөрийг бэлэн мөнгөөр гүйцэтгэх ба төлбөрийн ний дүн 300,000 төгрөгөөс, тээвэр шатахууны хэмжээ 500,000 төгрөгнөөс хэтрэхгүй" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Арилжааны банкинд байршиж байгаа дансыг хаах албан шаардлага хүргүүлэв.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Нэг. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Төсөв захирагч өөрийн дансаар сэлбэг, шатахуун бараа материалын 4,067.6 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Албан тушаалтан өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхолд нийцүүлэн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт

хийх, хариуцлага хүлээлгэх, мөн эдгээрт бэлтгэхэд өөрийн албан тушаалын байдлаа ашиглан аливаа хэлбэрээр хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсөв захирагч өөрийн дансаар бараа материал, хөрөнгө худалдан авах гүйлгээ хийхгүй байх.

Хоёр. Шатахууны зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Шатахууны зардлаас 127,894.9 мянган төгрөгийн буюу 58.0 хувийг гаднын автомашинд хийж зарцуулсан боловч жолоочийн тооцооны хуудас хөтлөөгүй, тооцоо бодоогүй, зарцуулалт тодорхой бус, шатахууны 89,268.1 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэж, төсвийг зохистой удирдаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 70 дугаар зүйлийн 70.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч тухайн жилийн төсвийн тухай хуульд заасан зардлыг хэтрүүлсэн, ангилал зөрүүлсэн, зориулалт бусаар ашигласан бол тухайн эрхэлж байгаа албан тушаалаас чөлөөлөх үндэслэл болно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Гадны байгууллагын машинд шатахуун олгохгүй байх, зарцуулалтад хяналт тавьж ажиллах.

Гурав. Худалдан авалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Шатахууны зардлаас 65,492.4 мянган төгрөг, багаж техник хэрэгсэл худалдан авах зардлаас 61,026.0 мянган төгрөг, урсгал засвараас 65,129.0 мянган төгрөг, бусад хөрөнгө буюу хөрөнгө оруулалтын зардлаас 246,500.0 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, өмнөх зөрчлийг давтан гаргасан нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно.", Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13-т "албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Босго үнээс давсан төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ хуулийн дагуу худалдан авах ажиллагаа зохион байгуулж байх.

Дөрөв. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Нэгдсэн үндэсний байгууллагын санхүүжилтээс өмнөх оны дотоод албан томилолт 7,070.0 мянган төгрөгийг олгосон боловч өр төлбөрийг дансанд бүртгээгүй, ажлын тайлан, илтгэх хуудасгүй, 3,500.0 мянган төгрөгийг зарцуулсан шатахууны зарцуулалтын баримт хангалтгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна.", 47.3-т "Энэ хуулийн 47.1.2, 47.1.6-д

заасан орлогыг зөвхөн батлагдсан төсвийн хүрээнд зарцуулна.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нэгдсэн Үндэстний байгууллагаас өгсөн санхүүжилтийг анхан шатны баримтыг үндэслэн зарцуулах, дотоод хяналтыг сайжруулах.

Тав. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчин ЗДТГ-ын урсгал төсвөөс 299,252.1 мянган төгрөгийг дараах арга хэмжээнүүдэд зарцуулсан байна. Үүнд:

- Аймгийн Засаг даргаас бусад алба нэгжийн хэлтсийн дарга нар суудлын автомашин ашиглаж, 33,977.0 мянган төгрөгийг,
- Аймгийн Засаг даргын цэргийн зориулалттай хувцас хийлгэхэд 1,329.5 мянган төгрөгийг,
- Тухайн сард зохион байгуулах тодорхой бус арга хэмжээнүүдэд ЗДТГ-ын даргын тушаалаар бараа үйлчилгээний бусад зардлаас 33,010.3 мянган төгрөгийн хоол, хүнс, буудлын төлбөрт 27,363.3 мянган төгрөгийг,
- Аймгийн ЗДТГ-ын бүтцийн нэгжийн ажилтнууд нутгийн золголтод оролцоход албан томилолтын зардалд 3,740.0 мянган төгрөгийг,
- Аймгийн баяр наадмын зардалд 191,832.0 мянган төгрөгийг анхан шатны баримтгүй, үр ашиггүй, арвилан хэмнэлттэй зарцуулж, 8,000.0 мянган төгрөгөөр айраг ундаа авчээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах," Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т "Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймаг, сум, баг, нийслэл, дүүргийн Засаг даргаас бусад этгээд албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно." 6.3-т "Энэ хуулийн 3.1-д заасан этгээд орон нутагт албан томилолтоор, хуульд заасан эрх бүхий этгээд газар дээрх хяналт шалгалтаар ажиллахад хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн автотээврийн байгууллагаар үйлчлүүлэхээс бусад тохиолдолд автомашин ашиглахыг хориглоно". 8 дугаар зүйлийн 8.1- д "Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно.", 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад", 15 дугаар зүйлийн зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", 15.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах"; 15 дугаар зүйлийн 15.1.7-д "байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах", 15.2.7-т "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх". гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөн хууль тогтоомжоор зөвшөөрөөгүй зардал гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлээ

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийлэл, зөрчлийн нэгтгэл:

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж					
		Тоо		Дүн		Тоо		Дүн		Залруулсан		Залруулаагүй		Тоо		Дүн	
		3	4	5	6	7	8	9	10	тоо	Дүн	тоо	Дүн	Тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14				
	Нэмэлт санхүүжилтийн дансаар орж ирсэн 862.3 мянган төгрөгийн орлогыг үндсэн дансны туслах үйл ажиллагааны орлогоор тайлагнасан.	1	862.3	-	-	-	1	862.3	-	-	-	-	-				
Аймгийн Засаг даргын тамгын газр	Нэмэлт санхүүжилтийн данснаас төвлөрүүлсэн 22,133.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт 213303 эдийн засгийн ангиллаар тайлагнасан.	1	22,133.6	-	-	1	22,133.6	1	22,133.6	-	-	-	-				
	Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 14,949,023.1 мянган төгрөгийн 333 мэдээллээс, цалингаас бусад 5 саяаас дээш зарлагын 975,735.6 мянган төгрөгийн 20 гүйлгээг мэдээлээгүй, мэдээлээгүй.	1	975,735.6	1	975,735.6	-	-	1	975,735.6	-	-	-	-				
	ДҮН	3	998,731.6	1	975,735.6	2	22,996.0	3	998,731.6	-	-	-	-				

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага			
		Тоо		Дүн		Тоо		Дүн		Тоо		Дүн	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12		
	Төрийн хэмнэлтийн тухай хууль болон баталсан бүтэц орон тооны хязгаарыг зөрчин аймгийн Засаг даргын орлогч 1-ээр илүү ажиллуулсан 61,106.2 мянган төгрөгийн, 1-8 сард зөвлөх ажиллуулсан 37,741.4 мянган төгрөгийн, 9-12 сард төслийн зохицуулагч орон тоог бий болгон 16,404.0 мянган төгрөгийн, нийт	1	115,251.6	-	-	1	115,251.6	-	-	-	-		
	ДҮН	3	998,731.6	1	975,735.6	2	22,996.0	3	998,731.6	-	-		

Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аймгийн Засаг даргын тамгын газр	115,251.6 мянган төгрөгийн цалин олгож, төсвийг үрэлгэн зарцуулсан.	1	40,315.0	1	40,315.0	-	-	-	-
	Төсөвт тусгагдаагүй байхад ажиллагсад 12 сард өдөрт 45.0 мянган төгрөгөөр тооцож, нийт 40,315.0 мянган төгрөгийн хоолны мөнгийг давхардуулан олгож төсвийг үрэлгэн зарцуулсан.	1	40,315.0	1	40,315.0	-	-	-	-
	Нэгдсэн үндэсний байгууллагын санхүүжилтээс өмнөх оны дотоод албан томилолт 7,070.0 мянган төгрөгийг олгосон боловч өр төлбөрийг дансанд бүртгээгүй, ажлын тайлан, илтгэх хуудасгүй, 3,500.0 мянган төгрөгийг зарцуулсан шатахууны зарцуулалтын баримт хангалтгүй.	1	10,570.0	-	-	10,570.00	-	-	-
	Байгууллагын нэр дээрх 5315620466 тоот картын дансаар дамжуулан, ангилагдаагүй бусад арга хэмжээний зардлаас 131,132.7 мянган төгрөгийн 39 гүйлгээг каст бэлэн мөнгөөр гарган авч зарцуулсан боловч бэлэн мөнгөний орлого, зарлагын гүйлгээний анхан шатны баримтгүй.	1	131,132.7	-	1	131,132.7	-	-	-
	Тус байгууллагын дансанд бүртгэлтэй олон жилийн насжилттай 264,522.8 мянган төгрөгийн өвс тэжээлийн авлага үүсгэсэн боловч эзэн холбогдогч тодорхойгүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	1	264,522.8	-	1	264,522.8	-	-	-
	Төсөв захирагч өөрийн дансаар сэлбэг, шатахуун бараа материалын 4,067.6 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн байна.	1	4,067.6	-	-	-	1	4,067.6	-
	Шатахууны зардлаас 127,894.9 мянган төгрөг буюу 58.0 хувийг гадны автомашинд хийж зарцуулсан боловч жолоочийн тооцооны хуудас хөтлөөгүй, тооцоо бодоогүй, зарцуулалт тодорхой бус, шатахууны 89,268.1 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэж, төсвийг зохистой удирдаагүй.	1	127,894.9	-	-	-	1	127,894.9	-
	Шатахууны зардлаас 65,492.4 мянган төгрөг, багаж техник хэрэгсэл худалдан авах зардлаас 61,026.0 мянган төгрөг, урсгал засвараас 65,129.0 мянган төгрөг, бусад хөрөнгө буюу хөрөнгө оруулалтын зардлаас 246,500.0 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, өмнөх зөрчлийг давтан гаргасан байна.	1	438,147.4	-	-	-	1	438,147.4	-
	Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчин ЗДТГ-ын урсгал төсвөөс 299,252.1 мянган төгрөгийг дараах арга хэмжээнүүдэд зарцуулсан байна. Үүнд: 1.Аймгийн Засаг даргаас бусад алба нэгжийн		299,252.1					299,252.1	



Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

	<p>хэлтсийн дарга нар суудлын автомашин ашиглаж шатахуунд 33,977.0 мянган төгрөгийг, 2.Аймгийн Засаг даргын цэргийн зориулалттай хувцас хийлгэхэд 1,329.5 мянган төгрөгийг, 3. Тухайн сард зохион байгуулах тодорхой бус арга хэмжээнүүдэд ЗДТГ-ын даргын тушаалаар бараа үйлчилгээний бусад зардлаас 33,010.3 мянган төгрөгийн хоол, хүнс, буудлын төлбөр, 27,363.3 мянган төгрөгийг, 4.Аймгийн ЗДТГ-ын бүтцийн нэгжийн ажилтнууд нутгийн золголтод оролцоход албан томилолтын зардалд 3,740.0 мянган төгрөгийг, 5.Аймгийн баяр наадмын зардалд 191,832.0 мянган төгрөгийг анхан шатны баримтгүй, үр ашиггүй, арвилан хэмнэлтгүй зарцуулж, 8,000.0 мянган төгрөгөөр айраг ундаа авсан.</p>	1				
	<p>Нийт</p>	9	1,431,154.3	4	551,222.2	5 879,932.12

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо						Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах		Үүнээс: Аудит хийсэн хэлбэр				Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан	
		Аудитад хамрагдсан	Түвшэрт хамруулсан	Санал дүгнэлт гаргасан	Аудит хийгээгүй	Аудит хийсэн хэлбэр						
A	1	2	3	4	5	7	8	9	10			
1	ТШЗ		1				1					
	НИЙТ		1				1					

